



БЯАН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 4/507

Өлгий

Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэх
шуурхай үйл ажиллагаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээр, нийтийн эзэмшлийн газар нутаг болон төв, орон нутгийн чанартай замын ойролцоо үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм их болж байгаль орчин бохирдон, хүн, мал, амьтны халдварт өвчин дамжин тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх онцгой шаардлагыг үндэслэн орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэх шуурхай үйл ажиллагааг 2019 оны 7 дугаар сарын 02-наас, 7 дугаар сарын 24-ны хооронд зохион байгуулан явуулсугай.

2.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, малын хашаа, хороонд ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж, дүнг нэгтгэн гүйцэтгэлийн тайланг 7 дугаар сарын 24-ны дотор гарган аймгийн Мал эмнэлгийн газарт ирүүлэхийг нийт сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэх шуурхай үйл ажиллагаа зохион байгуулан, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Мал эмнэлгийн газар /А.Айдынасхар/-т, арга хэмжээний явц гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Мухамед/-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Ш.ХАВЫЛ

0101131128